



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А/133

Улаанбаатар хот

“Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын
наадамд уран бүтээлчдийг оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/616 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор зохион байгуулагдаж буй “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадамд оролцож, дүүргийн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч, ардын авьяастан, уран бүтээлчдийн тоглолтыг зохион байгуулсугай.

2. Наадамд оролцоход зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 2,781,120 (Хоёр сая долоон зуун наян нэгэн мянга нэг зуун хорь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, уран бүтээлчдийн оролцоог хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны... сарын...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт



“ДАНШИГ НААДАМ-ХҮРЭЭ ЦАМ” ШАШИН СОЁЛЫН НААДАМД
ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Бүгд үнэ	Тайлбар
1	Шатахуун	л	3,990	88	351,120	-
2	Хоол	ш	13,500	180	2,430,000	2 өдөр 45 уран бүтээлч өдрийн 2 хоол
Нийт дүн					2,781,120	